



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/644

Улаанбаатар хот

Дүрэмд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Засгийн газрын 2024 оны 81 дүгээр тогтоолын 1.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Нийслэлийн ерөнхий архитектор Хот байгуулалтын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг хангаж Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/478 дугаар захирамжаар баталсан "Хот байгуулалт, хотын стандартын газрын дүрэм"-д дор дурдсан агуулга, заалтыг нэмсүгэй:

1.1. Дүрмийн "1.5. Нийслэлийн ерөнхий архитектор нь зохих журмын дагуу үйлдсэн албан бичиг, тушаал, албан даалгаврын хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ." гэж;

1.2. дүрмийн "6.3 дахь заалтын "... Нийслэлийн Засаг даргын Тамгын газар" гэсний өмнө "Нийслэлийн ерөнхий архитектор болон" гэж";

1.3. дүрмийн "6.5. Нийслэл хотын ерөнхий архитектор нь Хот байгуулалтын тухай хууль, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан "Аймаг, нийслэл, хотын ерөнхий архитекторын дүрэм" болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх ба энэхүү чиг үүргийн хүрээнд тушаал, шаардлагатай бусад шийдвэрийг гаргана." гэж;

1.4. дүрмийн "7.4. Хот байгуулалтын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан Нийслэлийн ерөнхий архитекторын эрх, үүргийн хүрээнд гаргасан тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллана." гэж тус тус нэмэх.

2. Дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Нийслэлийн ерөнхий архитектор (Ч.Төгсдэлгэр)-т, Хот байгуулалт, хотын стандартын газар (Г.Баярсайхан)-т, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Д.Амгалан)-т тус тус үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Х.НЯМБААТАР

1725023073